



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны гуравдугаар цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/085/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ШААМАР СУМЫН ДУЛААНХААН
ТОСГОНЫ ГУРАВДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ЭНХМАА ТАНАА**

2026.02.25 № СЭА-2026/085/НА-СТА-ТШЗ

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны гуравдугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Шаамар сумын Дулаанхаан тосгоны гуравдугаар цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/228 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 14,169.7 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тод-руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	68,930,292.10	46,259,631.27
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		68,930,292.10	46,259,631.27
3121	Төгрөг		68,930,292.10	46,259,631.27
31211	Төрийн сангийн харилцах		68,930,292.10	46,259,631.27
33	АВЛАГА	5	1,100,000.00	1,100,000.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,100,000.00	1,100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6	13,394,650.18	12,598,417.18
354	Хангамжийн материал		13,394,650.18	12,598,417.18
3541	Бичиг хэргийн материал		2,038,441.50	2,038,441.50
3542	Аж ахуйн материал		9,290,894.68	9,290,894.68
3546	Хүнсний материал		856,859.00	60,626.00
3547	Бусад хангамжийн материал		1,208,455.00	1,208,455.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		83,424,942.28	59,958,048.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,221,398,566.96	1,206,977,884.64
392	Биет хөрөнгө		1,214,221,567.04	1,199,850,884.76
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,287,600,000.00	1,287,600,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(100,146,666.48)	(121,606,666.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		50,193,787.34	51,592,139.34
39206	Хуримтлагдсан элэгдэл		(26,844,376.08)	(22,485,340.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		4,657,253.06	7,191,108.46
39208	Хуримтлагдсан элэгдэл		(2,789,485.80)	(3,075,221.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө		1,731,450.00	1,731,450.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(750,295.00)	(1,096,585.00)
39217	Ном		569,900.00	
393	Биет бус хөрөнгө		7,176,999.92	7,126,999.88
39301	Програм хангамж		250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(100,000.08)	(150,000.12)
39303	Бусад биет бус хөрөнгө		7,027,000.00	7,027,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,221,398,566.96	1,206,977,884.64
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,304,823,509.24	1,266,935,933.09
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР			
51	Засгийн газрын хувь оролцоо		1,304,823,509.24	1,266,935,933.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		92,623,427.80	92,623,427.80
51101	Өмч: - төрийн		92,623,427.80	92,623,427.80
512	Хуримтлагдсан үр дүн		1,108,890,215.95	1,071,002,639.80
5121	Өмнөх үеийн үр дүн		1,108,890,215.95	1,108,890,215.95
5122	Тайлант үеийн үр дүн			(37,887,576.15)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		103,309,865.49	103,309,865.49
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,304,823,509.24	1,266,935,933.09
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,304,823,509.24	1,266,935,933.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тод-руулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,065,750,329.34	1,209,280,673.13
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		995,849,700.00	1,156,636,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		995,849,700.00	1,156,636,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		69,900,629.34	52,644,273.13
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		69,900,629.34	52,644,273.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		4,835,000.00	25,293,509.64
120	Нийтлэг татварын бус орлого		4,835,000.00	25,293,509.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		35,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00	35,000.00
120009	Бусад орлого		4,800,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө			12,030,309.64
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал			13,228,200.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	1,070,585,329.34	1,234,574,182.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,100,999,004.18	1,271,033,858.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,089,219,704.28	1,261,820,558.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		785,729,938.87	955,821,888.53
210101	Үндсэн цалин		500,597,262.25	573,361,153.56
210102	Нэмэгдэл		241,553,726.62	313,827,504.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт			26,650,000.00
210104	Урамшуулал		43,578,950.00	41,983,230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		97,727,131.82	119,146,234.30
210201	Тэтгэврийн даатгал		67,811,008.74	82,742,548.13
210202	Тэтгэмжийн даатгал		7,980,523.03	9,734,417.40
210203	ҮОМШӨ-ний даатгал		3,937,461.72	5,229,117.72
210204	Ажилгүйдлийн даатгал		3,599,627.82	4,290,232.57
210205	Эрүүл мэндийн даатгал		14,398,510.51	17,149,918.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		66,313,009.22	47,644,273.13
210301	Гэрэл, цахилгаан		8,657,789.69	9,703,047.53
210302	Түлш, халаалт		57,155,219.53	36,357,225.60
210303	Цэвэр, бохир ус		500,000.00	1,584,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		945,463.66	243,000.00
210401	Бичиг хэрэг		146,163.66	243,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		799,300.00	
2105	Нормативт зардал		71,225,737.30	69,613,519.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		74,000.00	
210502	Хоол, хүнс		71,151,737.30	69,613,519.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,470,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар		2,470,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,059,200.00	3,350,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,059,200.00	3,350,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		62,749,223.41	61,000,943.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		23,714,049.75	25,288,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,002,700.00	5,733,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		33,032,473.66	29,979,443.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,779,299.90	9,213,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		11,779,299.90	9,213,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		11,779,299.90	9,213,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,100,999,004.18	1,271,033,858.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		(30,413,674.84)	(36,459,676.15)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН			
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		285,416,570.20	1,427,900.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		285,416,570.20	1,427,900.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(285,416,570.20)	(1,427,900.00)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		(315,830,245.04)	(37,887,576.15)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,070,585,329.34	1,209,315,673.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,835,000.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,835,000.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00
120009	Бусад орлого	4,800,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,065,750,329.34	1,209,280,673.13
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	995,849,700.00	1,156,636,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	995,849,700.00	1,156,636,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,900,629.34	52,644,273.13
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,900,629.34	52,644,273.13
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,062,950,226.53	1,227,029,981.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,062,950,226.53	1,227,029,981.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,051,170,926.53	1,217,816,681.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	785,669,769.08	955,960,224.37
210101	Үндсэн цалин	488,423,722.95	574,544,458.52
210102	Нэмэгдэл	255,000,594.81	313,135,575.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт		26,435,000.00
210104	Урамшуулал	42,245,451.32	41,845,190.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,786,179.11	119,007,898.46
210201	Тэтгэврийн даатгал	67,611,300.00	82,277,140.46
210202	Тэтгэмжийн даатгал	7,954,200.00	9,185,839.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,977,200.00	4,603,157.56
210204	Ажилгүйдлийн даатгал	3,652,539.53	4,585,981.94
210205	Эрүүл мэндийн даатгал	14,590,939.58	18,355,779.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,430,629.34	47,644,273.13
210301	Гэрэл, цахилгаан	9,225,824.50	9,703,047.53
210302	Түлш, халаалт	57,704,804.84	36,357,225.60
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	1,584,000.00
2105	Нормативт зардал	71,411,649.00	68,817,286.00
210502	Хоол, хүнс	71,411,649.00	68,817,286.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,470,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	2,470,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,059,200.00	3,350,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,059,200.00	3,350,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,343,500.00	18,036,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,538,800.00	12,303,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,804,700.00	5,733,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,779,300.00	9,213,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,779,300.00	9,213,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,779,300.00	9,213,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,635,102.81	(17,714,308.83)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,342,700.00	4,956,352.00
	Дотоод эх үүсвэрээр	6,342,700.00	4,956,352.00
223001	Бусад хөрөнгө	6,342,700.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		4,956,352.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,342,700.00)	(4,956,352.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,292,402.81	(22,670,660.83)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		68,930,292.10
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		46,259,631.27

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,623,427.80	103,309,865.49	1,108,890,215.95	1,304,823,509.24
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			(37,887,576.15)	(37,887,576.15)
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,623,427.80	103,309,865.49	1,071,002,639.80	1,266,935,933.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,274,682,100.00	1,209,280,673.13	65,401,426.87	94.9
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,220,593,100.00	1,156,636,400.00	63,956,700.00	94.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,157,209,400.00	1,156,636,400.00	573,000.00	100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	63,383,700.00		63,383,700.00	-
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,089,000.00	52,644,273.13	1,444,726.87	97.3
132001	Орон нутгийн төсвөөс	54,089,000.00	52,644,273.13	1,444,726.87	97.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		35,000.00	(35,000.00)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00	(35,000.00)	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,274,682,100.00	1,209,315,673.13	65,366,426.87	94.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,274,682,100.00	1,231,986,333.96	42,695,766.04	96.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,265,468,800.00	1,222,773,033.96	42,695,766.04	96.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	992,478,400.00	955,960,224.37	36,518,175.63	96.3
210101	Үндсэн цалин	605,581,900.00	574,544,458.52	31,037,441.48	94.9
210102	Нэмэгдэл	339,076,900.00	313,135,575.51	25,941,324.49	92.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	26,435,000.00	(26,435,000.00)	
210104	Урамшуулал	47,819,600.00	41,845,190.34	5,974,409.66	87.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,934,800.00	119,007,898.46	3,926,901.54	96.8
210201	Тэтгэврийн даатгал	83,376,200.00	82,277,140.46	1,099,059.54	98.7
210202	Тэтгэмжийн даатгал	9,889,600.00	9,185,839.50	703,760.50	92.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,944,900.00	4,603,157.56	341,742.44	93.1
210204	Ажилгүйдлийн даатгал	4,944,900.00	4,585,981.94	358,918.06	92.7
210205	Эрүүл мэндийн даатгал	19,779,200.00	18,355,779.00	1,423,421.00	92.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,089,000.00	47,644,273.13	1,444,726.87	97.1

210301	Гэрэл, цахилгаан	11,000,000.00	9,703,047.53	1,296,952.47	88.2
210302	Түлш, халаалт	36,358,000.00	36,357,225.60	774.40	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,731,000.00	1,584,000.00	147,000.00	91.5
2105	Нормативт зардал	69,390,300.00	68,817,286.00	573,014.00	99.2
210502	Хоол, хүнс	69,390,300.00	68,817,286.00	573,014.00	99.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,350,700.00	3,350,700.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,350,700.00	3,350,700.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,225,600.00	22,992,652.00	232,948.00	99.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,492,300.00	17,259,352.00	232,948.00	98.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,733,300.00	5,733,300.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,213,300.00	9,213,300.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,213,300.00	9,213,300.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,213,300.00	9,213,300.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		6,988,810.00	(6,988,810.00)	
	Дотоод эх үүсвэрээр		6,988,810.00	(6,988,810.00)	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		6,988,810.00	(6,988,810.00)	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,274,682,100.00	1,238,975,143.96	35,706,956.04	97.2
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		68,930,292.10	(68,930,292.10)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		46,259,631.27	(46,259,631.27)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
3	Төсвийн байгууллага	1	1		
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	32		
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
28	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	19	19		
32	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1		
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12		

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,585.2 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд 243.0 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлыг бичиг хэргийн зардлаар, 591.1 мянган төгрөгийн цахилгааны зардлыг засгийн газрын дотоод шилжүүлэг зардлаар тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд 160.0 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлыг тээвэр шатахууны зардлаар, 591.1 мянган төгрөгийн цахилгааны зардлыг засгийн газрын дотоод шилжүүлэг зардлаар тайлагнасан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд

УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...”, санхүүгийн тайлангийн “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **2,379.2** мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс 399.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 1,980.2 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **2,379.2** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 8,630.8 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Багшийн хөгжлийн зардлаас программын сургалтын зардалд 199.0 мянган төгрөгийг, АЗ сертификатын сургалтын зардалд 200.0 мянган төгрөгийг гарган зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Боловсролын сайдын 2024 оны А/279 тушаалын 4 дүгээр хавсралтын 1.2 дахь “*Багшийн хөгжлийн зардлыг ... багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих болон багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн сургалтыг санхүүжүүлэхэд зарцуулна*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлыг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс татварын бүртгэлээр ХХОАТ-ын авлага 1,970.2 мянган төгрөг, Суутган төлөгчийн хувь хүнд суутгасан орлогоос суутгасан албан татварын өр төлбөр 10.0 мянган төгрөг байгаа боловч балансад тусгагдаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.2-д “*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага*”, 14.4.3-д “*бүх өр төлбөр*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд, санхүүгийн тайлангийн “Толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлан гарахаас өмнө тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж байх зөвлөмж хүргүүлээ.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үр дүнгийн тайланд зардлыг буруу ангилан бүртгэсэн	1	834.1			1	834.1	1	834.1				
Мөнгөн гүйлгээний зардлыг буруу ангилан тайлагнасан.	1	751.1			1	751.1	1	751.1				
Дүн	2	1,585.2			2	1,585.2	2	1,585.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардлыг зориулалт бусаар зарцуулсан.	1	399.0			1	399.0						
Тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн боловч балансд тусгагдаагүй.	1	1,980.2					1	1,980.2				
Дүн	2	2,379.2			1	399.0	1	1,980.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Дүн								
Нийт дүн								

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			